



**МӨНГӨ УГААХ БОЛОН
ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2018 он

Агуулга

- Монгол Улс гишүүн орон нь болсон Олон улсын байгууллагууд
- Монгол Улсын 2 дах удаагийн Харилцан үнэлгээний тайлан – Үндэсний зөвлөлийг байгуулах хэрэгцээ, шаардлага
- МУТСТ-тэй холбоотой одоогийн нөхцөл байдал
- Үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, чиг үүрэг
- Үндэсний зөвлөлөөс удирдан хийгдсэн ажлууд
- Үндэсний хөтөлбөр
- Өөрчлөлт оруулах шаардлагатай хууль тогтоомж
- МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- “Саарал жагсаалт”-д орох үр дагавар
- Харилцан үнэлгээний тайлантай холбоотойгоор манай улсад тулгарч буй асуудлууд
- Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улс гишүүн орон нь болсон Олон улсын байгууллагууд

- Монгол Улс нь Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /FATF буюу ФАТФ/-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)-ын гишүүнээр 2004 оны 6-р сард элсэв.
- ФАТФ нь Дэлхийн Санхүүгийн тагнуулын албадын олон улсын нийгэмлэг /EGMONT буюу Эгмонт/-ийн зарчим, тодорхойлолтод нийцсэн албыг байгуулж ажиллуулахыг улс орнуудад уриалдаг.
- Монгол Улс 2006 оны 7-р сарын 8-нд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ тухай хууль баталснаар СМА-ыг байгуулж МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлэв.
- ФАТФ нь МУТСТ олон улсын зөвлөмжийг батлахаас гадна гишүүн улс орнуудын МУТСТ тогтолцоог тодорхой хугацааны давтамжтай, тогтмол үнэлж, хянадаг. Энэ үйл явцыг Харилцан үнэлгээ гэдэг.



Asia/Pacific Group
on Money Laundering





Asia/Pacific Group
on Money Laundering

Монгол Улсын 2 дахь Харилцан үнэлгээний тайлан

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG) Монгол Улсын МУТСТ тогтолцооны 2 дахь удаагийн харилцан үнэлгээг 2016 оны 4-р сараас 2017 оны 7-р сарын хооронд хийсэн бөгөөд APG нь 2017 оны 9 дүгээр сарын 5-нд өөрийн цахим хуудаснаа Монгол Улсын Харилцан үнэлгээний тайланг нийтлэв.


- Монгол Улсын МУТСТ тогтолцоог үнэлэх 2 дахь удаагийн Харилцан үнэлгээ ихээхэн онцлог байв:
- Харилцан үнэлгээ нь ФАТФ-аас 2012 онд шинэчлэн баталсан 40 Зөвлөмжийн дагуу хийгдсэн.
- Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт (хууль, эрх зүй болон үйл ажиллагааны тогтолцоо)-ийг төдийгүй МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг давхар үнэлснээрээ онцлог байв.

Монгол Улсын 2 дахь Харилцан үнэлгээний тайлан – Үндэсний зөвлөл байгуулах хэрэгцээ шаардлага

Монгол Улсын техник хэрэгжилтийн үнэлгээ харьцангуй гайгүй хэдий ч Монгол Улсын үр дүнтэй байдлын үнэлгээ хангалтгүй байгаа юм.


Иймд Монгол Улсын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны харилцан үнэлгээний техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс Үндэсний зөвлөлийг байгуулсан.

ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



Монгол улсын
МУТСТ
ТОГТОЛЦООНЫ
ОДООГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ – Техник
хэрэгжилтийн
үнэлгээ

ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



Монгол улсын
МУТСТ
ТОГТОЛЦООНЫ
ОДООГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ – Үр
дүнтэй байдлын
үнэлгээ

Үндэсний зөвлөлийн танилцуулга

- МУ-ын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны харилцан үнэлгээний техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс Ерөнхий сайдын 2017 оны 4-р сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжийн дагуу ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙГ дараах бүтэцтэйгээр байгуулсан байна:

- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд (Зөвлөлийг даргална);
- Сангийн дэд сайд;
- Гадаад харилцааны дэд сайд;
- Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Улсын ерөнхий прокурорын орлогч;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга;

- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- Тагнуулын ерөнхий газрын тэргүүн дэд дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга;
- Татварын ерөнхий газрын дэд дарга;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга;

Үндэсний зөвлөлийн танилцуулга

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд Монгол Улсын Их хурлын тогтоолд МУТСТ талаар оруулсан заалт:

“Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, эрх зүйн орчныг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-аас тогтоосон олон улсын стандарт, зөвлөмжтэй нийцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.”

Үндэсний зөвлөлийн чиг үүрэг

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой давтамжтайгаар үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах,

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах,

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах,

Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж уялдуулах,

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах.

Үндэсний зөвлөлөөс хийгдсэн ажлууд

- 2017 оны 05-р сарын 17-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газраар батлах тухай шийдвэр гарсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөг баталсан.
- 2018 оны 01-р сарын 03-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг Засгийн газраар хэлэлцүүлсэн.
- 2017 оны 2 дугаар улирлаас хойш хийж гүйцэтгэсэн ажлуудын тайланг Засгийн газарт танилцуулсан.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлүүд

Үндэсний зөвлөл нь дунд хугацааны хөтөлбөр болон Харилцан үнэлгээний тайланд үндэслэн дараах чиглэлүүдээр хийгдэх ажлуудыг үе шаттайгаар удирдан явуулна. Үүнд:

- 1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог хангах;
- 2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулж, салбарын эрсдэлийн үнэлгээ хийх суурь тавих;
- 3 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдлэг, мэдээллийг сайжруулах, санхүүгийн болон санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч салбарыг уг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 4 ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох;

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлүүд

5 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын хүрээг нэмэгдүүлэх;

6 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, гэмт хэргийн замаар олсон орлого, эд хөрөнгийг царцаах, битүүмжлэх чадавхыг бий болгох, хөгжүүлэх;

7 Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх;

8 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хянаж шийдвэрлэхэд шүүгч, прокурорын үйл ажиллагаа, ур чадварыг дээшлүүлэх;

9 Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хүчин чадал, механизмыг бэхжүүлэх;

10 Мөнгө угаахтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын боловсон хүчин, нөөц бололцоог бэхжүүлэх, сургалт, семинарт тогтмол хамруулах.

Өөрчлөлт оруулах шаардлагатай хууль ТОГТООМЖ

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль – 2018 оны дунд үе;
- Дагаж гарах хуулийн төсөл - Зөрчлийн тухай хууль (Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг авах хориг арга хэмжээг хэрэгжүүлэх г.м.) – 2018 оны дунд үе;
- Бизнесийн үйл ажиллагаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тавих шаардлага, шалгуурыг зохицуулсан шинэ журмууд – 2018 оны 9 дүгээр сар.

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

- МУТСТ тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 07 дугаар сарын 08-ний өдөр баталсан бөгөөд үүний дараагаар ФАТФ-ын тухайн үеийн зөвлөмжид нийцүүлэн МУТСТ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан.
- 2017 онд Монгол Улсын МУТСТ тогтолцоонд хийсэн Харилцан үнэлгээний тайлангаар тус хууль болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг тусгасан бөгөөд энэ хүрээнд шаардлагатай ажлуудыг хийж эхэлсэн.

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

- Хууль өөрөө цаг үе, нийгмийн хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, аливаа зөрчил, хийдэлгүй байх нийтлэг зарчимд тулгуурлан Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18, 12.2.24, 12.3.2 дахь заалтад тус тус үндэслэн Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага үүсэж, зөвлөмжийн дагуу дараах өөрчлөлтүүдийг төсөлд тусгасан:

- 1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүрээг өргөжүүлэх, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нийцүүлэх, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх;*
- 2. Эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх;*

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

3. Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгах;

4. Засгийн газрын түвшинд Үндэсний зөвлөл ажиллах зохицуулалтыг тусгах;

5. Хуулийн нэр томъёоны зарим тодорхойлолтыг ФАТФ-ын 40 зөвлөмжид заасан стандартад нийцүүлэх;

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

6. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа зохицуулалт нь “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх”-д нэг адил үйлчлэх талаар хуульд тусгана. Ингэхдээ терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх асуудалд тагнуулын байгууллага, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд Санхүүгийн мэдээллийн алба хуульд заасны дагуу хяналт тавихаар тусгах;

7. Мэдээллийн нууцлалыг хадгалах зохицуулалтыг Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжид нийцүүлэхээс гадна хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай уялдуулах;

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

8. *Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа зохицуулалт нь “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх”-д нэг адил үйлчлэх талаар хуульд тусгана. Ингэхдээ терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх асуудалд тагнуулын байгууллага, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд Санхүүгийн мэдээллийн алба хуульд заасны дагуу хяналт тавихаар тусгах;*

МУТСТ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

9. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулах.

“Саарал жагсаалтад” орох үр дагавар

- “Саарал жагсаалт”-д орох нь санхүүгийн системийн гадаад харилцаанд шууд нөлөөлж түншийн харилцаа зогсонги байдалд орох, хөрөнгө татах боломж буурах буюу хязгаарлагдах, банкуудын гадаад гүйлгээ зогсох г.м. сөрөг үр дагавартай.
- Улмаар үр дагавар нь нийт эдийн засагт шууд мэдрэгдэх болно. Тухайлбал, улс орны зээлжих зэрэглэл буурч ЗГ болон ААН-ийн хөрөнгө босгох зардал нэмэгдэх, хөрөнгө оруулалтын зардал өссөнөөр инфляцид сөргөөр нөлөөлж болзошгүй юм.
- Эдийн засагт мэдрэгдэх эрч хүч, үүсэх сөрөг үр дагавар нь өмнө нь саарал жагсаалтад орж байснаас хавьгүй их байх болно!!!

Харилцан үнэлгээний тайлантай холбоотойгоор манай улсад тулгарч буй асуудлууд

- Монгол Улсын МУТСТ тогтолцоог ФАТФ-ын 40-н зөвлөмжид нийцүүлэх;
- Бодлогын түвшинд МУТСТ-тэй холбоотой хийгдсэн үйл ажиллагаануудыг зангидах
- Корреспондент банкуудтай харилцах харилцааг алдахгүй байх;
- Монгол Улсад тулгамдаж буй тус асуудлуудын талаар олон нийтэд мэдээлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Яам, агентлагууд Харилцан үнэлгээний тайлантай нэгбүрчлэн танилцаж бүрэн ойлголт авах
 - Засгийн газраас баталсан Ажлын төлөвлөгөөг графикийн дагуу хийж гүйцэтгэх
 - УИХ-ын ЭЗБХ, гишүүдэд тусгайлан мэдээлэл хүргүүлэх;
 - Холбогдох хууль тогтоомжийг шуурхай батлуулах;
 - Дэд ажлын хэсгүүдийн ажлыг эрчимжүүлэх
-
- **Монгол Улсын ажиглалтын үе буюу 2018 оны 10 дугаар сараас өмнө ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн МУТСТ хууль, эрх зүйн орчноо яаралтай өөрчилж, хэрэгжүүлснээр эрчимтэй хяналтаас гарахад чухал алхам болно.**



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2018 он